

Төслийн нэр: Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл,

удирдлага зохицуулалтын нэгдсэн систем

Төслийн дугаар: ТӨБЗГ/20240103001

Төслийг санхүүжүүлэх эх үүсвэр: Улсын төсөв

Лавлах дугаар : 1.3.1

1. Ерөнхий зүйл

“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ”-ний 4.1.4-ийн 5 дахь заалтанд “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож, нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно.” гэж тусгасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх мэдээллийг цаг хугацааны алдагдалгүйгээр нэгдсэн мэдээллийн сангаас шуурхай татах, өгөгдлийн санд цуглуулсан өгөгдөлийг ашиглан дараагийн шийдвэр гаргалтанд ашиглах боломжийг бүрдүүлэх, үл хөдлөх хөрөнгө, газар гэх мэт хөрөнгүүдийн бүртгэлийг “ХҮР” мэдээллийн сантай холбох, төрийн өмчийн бүртгэлтэй холбоотой бүх процессыг тус програм хангамжаар дамжуулан хийгддэг болгох, анхдагч өгөгдөлийг тодорхойлж, шаардлагатай мэдээллүүдийг холбогдох мэдээллийн сангуудаас татах боломжийг бүрдүүлэх (Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэл мэдээллийн сангаас байгууллагын хаяг байршил удирдлагын мэдээллийг, Хөрөнгө худалдан авах ажиллагааны мэдээллийг худалдан авах ажиллагааны газрын цахим системээс, Авто тээврийн үндэсний төвийн мэдээллийн сангаас автомашины мэдээллийг, Санхүүгийн тайлангийн мэдээллийн Сангийн яамны баланс бүртгэлийн системээс, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын мэдээллийн сангаас газрын мэдээллийг гм), хөрөнгийн ангилал бүрээр нэгдсэн тайлан, анализ хийх боломжийг бүрдүүлэх, хөрөнгийн бүртгэлийг тухайн хөрөнгийн дэлгэрэнгүй шинж чанар бүрээр бүртгэх боломжийг бий болгох, хөрөнгөтэй холбоотой тогтоол шийдвэрийг бүртгэх хянах, тайлاغнах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөн, худалдах, дуудлага худалдааг нээлттэй болгон иргэдэд хялбар байдлаар худалдан авах нөхцөл бололцоог нээх, ухаалаг гар утсанд суурилсан аппликацийн нэвтрүүлэх. Хэрэглэгчийн удирдлагыг хэрэглэгчийн дүр тус бүрээр тохируулан Дан системээр нэвтрэх нөхцөлөөр хангасан програм хангамжийг боловсруулах шаардлагатай байна.

2. ТӨСЛИЙН ЦАР ХҮРЭЭ

Монгол улсын бүх төрийн болон орон нутаг, төсөвт 7000 орчим байгууллага. Өмчтэй холбоотой мэдээлэл авах солилцох хуулийн этгээд, дуудлага худалдаанд оролцох, актлагдсан барааны дэлгүүрээр үйлчлүүлэх, түрээсийн сонгон шалгаруулалтад оролцохыг сонирхогч иргэн, хуулийн этгээд.

3. Төслийн хүрээнд хийгдэх ажлууд

Даалгавар 1: Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлагын зохицуулалтын нэгдсэн системийн бодлогын даалгаварыг тендерт шалgarsnaas хойш ажлын 15 хоногийн дотор боловсруулж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар дамжуулан, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн системийн хөгжүүлэлтийг /программ/ эхлүүлнэ

Даалгавар 2: Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээлэлтэй холбоотой төрийн бусад мэдээллийн сангудын талаарх судалгаа


Даалгавар 3: Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн сангийн систем

- Хуулийн этгээдийн мэдээлэл
- Өмчийн бүртгэл
 - Хуулийн этгээдийн
 - Нийтийн өмч
- Хөрөнгийн хөдөлгөөн
- Тооллогын систем
- Тайлан мэдээ
- Архивын систем
- Санхүүгийн тайлан
- Түрээсийн систем
- Дуудлага худалдааны систем
- Актлагдсан барааны дэлгүүрийн систем
- Системийн дотоод хяналт
- Хэрэглэгчийн тохиргоо мэдээлэл
- Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын систем
 - Зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг төлөвлөх, хянах систем
 - Санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх систем
 - Компанийн засаглал, гүйцэтгэх удирдлагын үнэлгээний систем
 - Зорилтын саналын систем
- Албан бичиг хэрэг хөтлөх систем
- Хөрөнгө оруулалтын систем
- Өмчлөлийн бодлого, бүтцийн өөрчлөлтийн систем
- Хяналт шалгалтын систем
- Хууль эрх зүйн систем
- Системийн байгууллагуудын чат, мэдээллийн веб хуудас

Даалгавар 4: Шаардлагатай мэдээллийн сангудаас мэдээллийг татах илгээх дундын сан бий болгох, “ХҮР”, “ДАН” системтэй холбогдон ажиллах, тоон гарын үсэг нэвтрүүлэх

Даалгавар 5: Байгууллага, албан хаагчдад сургалт, нэвтрүүлэлт хийх

СИСТЕМИЙН БУТЭЦ



СИСТЕМИЙН БУТЭЦ

- TERIIN OMCHIIN BODLIGO, ZOHIIZULALTYN GAZAR**
- ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ**
 - Хувьцааны мэдээлэл
 - ТУЗ-ын мэдээлэл
 - Богино, дунд, урт хугацааны стратеги төлөвлөлт
 - ӨМЧИЙН БУРТГЭЛ (Хуулийн этгээдийн)**
 - Газар
 - Барилга
 - Байгууламж
 - Тээврийн хэрэгсэл
 - Машин, тоног төхөөрөмж
 - Тавилга, эд хогшил
 - Бусад /17-20 нэр төрлийн буртгэл/
 - ӨМЧИЙН БУРТГЭЛ (Нийтийн omchiiin)**
 - Газар
 - Газрын доорхи баялаг
 - Ургамал амьтны нөөц
 - Усан доорх баялаг
 - Ой модны доторх баялаг
 - Түүх соёлын дурсгалт цогцолбор
 - Археологийн олдвор
 - Бусад
 - ХӨРӨНГИЙН ХӨДӨЛГӨӨН**
 - Хөрөнгө солих
 - Хөрөнгө худалдан авах
 - Хөрөнгө бүртгэх
 - Хөрөнгө данснаас хасах
 - Хөрөнгө шилжүүлэх
 - Хөрөнгө дахин үнэлэх
 - Их засеарт оруулах
 - Бусад
 - ТАЙЛАН МЭДЭЭ**
 - Статистикийн маягт/15 маягт/
 - Териин omchiiin буртгэлийн маягт/12 маягт/
 - Динамик тайлан
 - Судалгааны маягтууд
 - Томоохон нийтлэг нэгтгэлүүд
 - Бусад
 - АРХИВИЙН СИСТЕМ (Бүх мэдээлэл, дата)**
 - Он дарааллаар архив үүсгэх /Жил бүрийн тегсэлд бүх мэдээллийг дахин засах боломжгүйгээр хааж, архивлаад шинэ оны мэдээлэлээ оруулж эхлэдэг болох/
 - Архивласан мэдээллийг тухайн цаг үеэр нь дахин дуудаж харах /Засварлах боломжгүй/

ТӨРИЙН
ӨМЧИЙН
БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- e-balance системээс санхүүгийн б тайланг шууд татдаг байх
- Санхүүгийн тайланд анализ, судалгаа хийдэг байх
- Санхүүгийн тайлангийн нэгтгэл хийгддэг байх

ТҮРЭЭСИЙН СИСТЕМ

- Түрээслүүлж байгаа хөрөнгийн систем
- Түрээслэж байгаа хөрөнгийн систем

ДУУДЛАГА
ХУДАЛДААНЫ СИСТЕМ

- Тээврийн хэрэгслийн
- Тоног төхөөрөмжийн
- Үл хедлэх хөрөнгийн

АКТЛАГДСАН
БАРААНЫ
ДЭЛГҮҮРИЙН СИСТЕМ

- Худалдан авагчийн модуль
- Удирдлагын модуль
- Хоёрдогч түүхий эдээр шууд худалдах

СИСТЕМИЙН ДОТООД
ХЯНАЛТ

- Алдаа шалгах модуль
- Тайлан мэдээг сануугийн тайлантай тулгах модуль
- Санхүүгийн программын мэдээллийг өөрийн мэдээлэлтэй тулгах модуль
- Мэдээлэл үнэн зөв эсэхийг нэгдсэн цонхоор хэрэглэгчид өгөх

ХЭРЭГЛЭГЧИЙН
ТОХИРГОО

- Хандах эрхийн түвшин тогтоох
- Хуулийн этгээдийн онцлогт тохирсон тохиргоо
- Бусад

ТӨРИЙН БОЛОН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН
УДИРДЛАГЫН СИСТЕМ

- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үзүүлэлт
- Хүний нөөцийн мэдээлэл
- Удирдлагын мэдээлэл
- Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт
- Бусад

ТӨРИЙН
ӨМЧИЙН
БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗАР

АЛБАН БИЧИГ ХЭРЭГ
ХӨТЛӨХ СИСТЕМ

- Албан хэрэг хөтлөлт
- Архив
- Тайлан судалгаа
- Зар мэдээлэл
- Цаг бүртгэл
- Тоон гарын үсэг

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН СИСТЕМ

- Их засварын арчилгаанууд
- Бусад

ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН
СИСТЕМ

- Процессийн мэдээлэл
- Гэх мэт

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
СИСТЕМ

- Шалгалтын график, үр дүн
- Төлөвлөгөөт шалгалт

ФОТО ЗУРГААР ХАЙЛТ
ХИХ

- Зургийн хэмжээг автоматаар тохируулах
- Зургаар дамжуулан хөрөнгийн мэдээлэл харах

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН
СИСТЕМ

- Журам боловсруулах
- Санал авах
- Маргаан шийдвэрлэлт

CHAT ROOM

- Системийн байгууллага дотор
- Удирдлага хооронд
- Админ-тай холбогдох
- Зар байршуулах

ТУСЛАМЖ

- Системийн гарын авлага /видео хичээл/
- Эрх зүйн холбогдолтой хууль, журам, тогтоолууд

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛУУДЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛБАР

Зөвлөх компани нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон холбогдох нэгжтэй шууд холбогдон ажиллана.

3.1 Даалгавар 1: Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээлэлтэй холбоотой төрийн бусад мэдээллийн сангүүдийн талаарх судалгаа

Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээлэл нь олон төрлийн системүүдтэй холбогдон ажиллах зайлшгүй шаардлагатай байдаг.

Зөвлөх компани нь тус төслийг гүйцэтгэх, шинэчлэн сайжруулахад зориулан мэргэшсэн эрдэмтэн судлаачдаас бүрдсэн судалгааны баг ажиллуулана.

Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл ашиглалтын одоогийн нөхцөл байдал, систем нэвтрүүлэх, хөгжүүлэх, сайжруулахад шаардлагдах мэдээ мэдээллийн судалгааг хийнэ.

Хийгдэх судалгаа

- Олон улсад төрийн өмчийн бүртгэлийн судалгаа
- Монгол улсын хуулийн этгээд, үл хөдлөх хөрөнгө, газар, статистик, татварын гм шаардлагатай мэдээллийн сан, програм хангамж, системүүдүүн судалгаа
- Төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудад ашиглагдаж буй нягтлан бодох бүртгэл, удирдлагын зэрэг ашиглагдаж буй мэдээллийн судалгаа
- Төрийн болон нутгийн өмчийн бүртгэл ашиглалтын хөндлөнгийн судалгаа

3.2 Даалгавар 2: Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн сангийн систем

Төрийн болон орон нутгийн мэдээллийн сангийн системийг захиалагч талтай шууд харилцан хамтран ажиллана. Системийн нэгдсэн нэг платформ дээр хийж дэд системүүдийг модуль хэлбэрээр зохион байгуулна. Иргэдэд зориулсан дуудлага худалдаа, актлагдсан барааны дэлгүүр, төрийн өмчийн байгууллагуудын портал веб хуудас, түрээсийн систем зэргийг гар утасны аппликацийн системтэй мэдээлэл солилцох хэлбэрээр тусад нь хөгжүүлэнэ.

3.2.1 Хуулийн этгээдийн мэдээлэл

Улсын бүртгэлийн ерөнхий газар, "ХҮР" системтэй холбогдон ажиллаж нээлттэй мэдээллийн сангаас шаардлагатай мэдээллийг холбогдон авна.

Хуулийн этгээдийн дээрх байгууллагын мэдээллийн санд байдаггүй ТУЗ, хувьцааны мэдээлэл, богино дунд, урт хугацааны стратеги төлөвлөгөө зэрэг мэдээллийг системийн санд оруулж өгнө.

Улсын бүртгэл, "ХҮР" дээрх мэдээллийн сантай зөрүүтэй мэдээллийг дундын сангаар дамжуулан мэдээллэж засварлуулна. Мэдээллийг давхардуулахгүй зөрүүтэй хадгалахгүй байх зарчмыг баримтална.

Нягтлан бодогч, өмч хамгаалах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл зэрэг тус системд шаардлагатай мэдээллийг тухайн байгууллага оруулан хяналтыг харьяалах дээд байгууллагын тухайн байгууллагыг хариуцан ажиллаж буй албан тушаалтан хяналт тавина.

Шаардлагатай мэдээллийн талбарыг super admin эрхтэй хэрэглэгч нэмж хасах боломжтой байна.

3.2.2. Өмчийн бүртгэл

-Төрийн нийтийн зориулалттай өмч

- иргэдэд өмчлүүлснээс бусад газар,
- газрын хэвлэй түүний баялаг
- Ус, түүний доторх баялаг, ой түүний доторх баялаг
- Ургамал, ан амьтны нөөц
- Түүх, соёлын үнэт цогцолбор, хөрөө дурсгал
- Археологийн олдвор, хуулийн тогтоосон бусад хөрөнгө

-Төрийн өөрийн өмч

Төрийн нийтийн өмчөөс бусад төр эзэмшиж, захиран зарцуулж болох дараах хөрөнгө:

- төрийн байгууллага албан газар эзэмшүүлсэн эд хөрөнгө
- ТӨҮГ-т эзэмшүүлсэн хөрөнгө
- ТӨО-той хуулийн этгээдийн төрд ногдох хувь
- Улсын төсвийн хөрөнгө болон төрийн бусад тусгай сан

Хуулийн этгээд тус бүрийн онцлогоос хамааран элэгдэлийг өөр өөрөөр тооцоолно.

3.2.2.1 Төрийн өөрийн өмчийн бүртгэл

• Газар

Газрын мэдээллийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын мэдээллийн сангаас хэрэгцээт мэдээллээ ХҮР системээр дамжуулан татаж авах ба тухайн санд тусгагдаагүй мэдээллийг тухайн байгууллага нэмж оруулна. Энэ хэсэгт ТӨБЗГ-ын 2020 оны 323 дугаар тогтоолоор батлагдсан ТӨХ-2 маягтын бүх мэдээлэл багтсан байна.

• Барилга

Энэ хэсэгт тухайн хуулийн этгээдийн барилга бүртгэгдэнэ Барилгын зарим мэдээллийг Барилга хот байгуулалтын Urban системтэй холбоно.

Админ:

- Шийдвэр гаргасан эрх бүхий байгууллага барилга бүртгэн авах тухай мэдэгдлийг системээр дамжуулан эзэмшигч байгууллагад мэдэгдэг байх

Хэрэглэгч байгууллага:

- Бүртгэх зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр болон орлогод авах тухай өөрийн байгууллагын шийдвэрийг бүртгэнэ
- Үндсэн барилга, туслах барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийн аль нь болох сонголтыг хийнэ. /Сонголт хийснээр цаашид гарч ирэх цонхнууд тухай хөрөнгөд зориулагдан өөрчлөгднөн/
- Байршилыг бүрэн бөглөхгүй бол цааш үйлдэл хийх боломжгүйгээр тохиргоог хийнэ. (Хаягжилтыг үнэн зөв байлгахын тулд хаягийн мэдээллийг системд бүрэн оруулах эсвэл холбогдох системээс мэлээлэл татдаг байх)
- Ашиглалтад орсон он сар өдөр, ашиглалтын нийт хугацааг тодорхой оруулж өгөх /шулуун шугамын аргаар элэгдэл тооцоолно/

- Хүчин чадал, ангиллын код, барилгын хийцийн код зэрэг стандартчилагдсан мэдээллүүдийг сонголтоор оруулж өгөх. (Гараас шивэх боломжгүйгээр). Жишээ нь: у/м, м.кв, хүүхдийн тоо гэх мэт

- Барилгын төлөв байдлын дүгнэлтийг тухай бүр хавсаргадаг байх
- Барилгын байршлын орчны тойм зураг /эсвэл системд хот төлөвлөлтийн хаягжилтын мэдээллийн санг холбож барилга тус бүр дээр байршилаа пин хийдэг байх/

Мөн барилгын зохион байгуулалтын схем зургийг хавсаргадаг байх

- **Байгууламж**
- **Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө**

Нийтийн эзэмшлийн хөрөнгийг бүртгэхдээ байршлыг маш тодорхой зааж өгөх /гэрэлтүүлэг бол эхлэл, төгсгөлийн цэг оруулах, тохижилтын ажил бол УБ.БЗД.11Хороо 12-р байрны дундах тохижилт гээд хөрөнгө тус бүрээрээ задрах/

- **Тээврийн хэрэгсэл**

Автотээврийн үндэсний төвийн мэдээллийн ХУР системээр дамжуулан татаж авна. Улсын дугаар олгогдоогүй тээврийн хэрэгсэл, болон нэмэлт мэдээллийг тухайн байгууллага оруулна Энэ хэсэгт ТӨБЗГ-ын 2020 оны 323 дугаар тогтоолоор батлагдсан ТӨХ-6 маягтын бүх мэдээлэл багтсан байна.

Оношлогоо хийгдсэн огноо

- **Машин, тоног төхөөрөмж**

Тухайн байгууллагын няглан бодох бүртгэлийн мэдээлэл дээр үндэслэн үндэсний статистикийн хорооны баталсан маягт, кодлол, мэдээллийн санд чухал шаардлагатай нэмэлт мэдээллүүдийг тухайн байгууллага оруулна. /Энэ ангилалд автомашин буюу тээврийн хэрэгсэл орохгүй/ хөрөнгө тус бүрээр бүртгэнэ.

- **Тавилга, эд хогшил**

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл дээр үндэслэн үндэсний статистикийн хорооны баталсан маягт, кодлол, мэдээллийн санд чухал шаардлагатай нэмэлт мэдээллүүдийг тухайн байгууллага оруулна.


- Бусад /17-20 нэр төрөл байна/

3.2.2.2 Нийтийн өмч

- Газар
- Газрын доор баялаг
- Ургамал амьтны нөөц
- Усан доорх баялаг
- Ой модны доторх баялаг
- Түүх соёлын дурсгалт цогцолбор
- Архилогийн олдвор
- Бусад
-


3.2.3 Хөрөнгийн хөдөлгөөн

Тухайн онд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний жагсаалтыг оруулдаг байх /бүргэсэн хөрөнгийн мэдээлэл энэ цэс рүү автоматаар татагддаг байх



- Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл хүсч буй байгууллага шаардлагатай бичиг баримтын бүрдлийг ханган хүсэлтээ ирүүлэх /эхлээд ямар хөрөнгө бүртгэх вэ гэдгийг сонгоно. Ямар хөрөнгөөс шалтгаалж бүрдүүлэх материалын жагсаалт өөрчлөгднө. Бүх материалыг хавсаргаж байж хүсэлт явдаг байх/
- Нийслэл болон орон нутгийн өмч хариуцсан байгууллагын тухайн байгууллагыг хариуцсан мэргэжилтэн хүсэлтийг шалган шаардлагатай бичиг баримт бүрэн бол хүсэлтийг хүлээж авна. Буруу болон дутуу материал ирүүлсэн бол буцаана.
- Хүсэлтийг хүлээн авсан мэргэжилтэн баримт бичгийг боловсруулан /үүнд: тогтоол, захирамж, ЭБХХХХурлаар хэлэлцүүлэх материал гэх мэт/ шийдвэр гаргана. Шийдвэр гарсан бүртгэлийг системд бүртгэн хүсэлт ирүүлсэн байгууллагыг сонгосноор тухайн байгууллагад хөрөнгө бүртгэж авах тухай мэдэгдэл очно. Уг мэдэгдлийн дагуу хөрөнгө орлогод авсан тэмдэглэл хөтөлнө /Үүнд: Даргын шийдвэрийн огноо, дугаар үнийн дүн гэх мэт/ /энэ хэсгийг ашиглан тогтоол шийдвэрийн биелэлт програмаас гарах боломжийг бүрдүүлэх/

1.1.1 Өмч хасах процесс




- Хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл хүсч буй байгууллага шаардлагатай бичиг баримтын бүрдлийг ханган хүсэлтээ ирүүлэх /эхлээд ямар хөрөнгө актлах вэ гэдгийг сонгоно. Ямар хөрөнгөөс шалтгаалж бүрдүүлэх материалын жагсаалт өөрчлөгднө. Бүх материалыг хавсаргаж байж хүсэлт явдаг байх/
- Нийслэл болон орон нутгийн өмч хариуцсан байгууллагын тухайн байгууллагыг хариуцсан мэргэжилтэн хүсэлтийг шалган шаардлагатай бичиг баримт бүрэн бол хүсэлтийг хүлээж авна. Буруу болон дутуу материал ирүүлсэн бол буцаана.
- Хүсэлтийг хүлээн авсан бол хүсэлт ирүүлсэн байгууллагатай холбогдон актлах хөрөнгийг биеээр очиж үзэх,

- Шаардлагатай танилцуулгыг боловсруулан хурлаар хэлэлцүүлнэ/санал авна. /Үүнд: иргэдийн хурал, захирамжийн төсөл, ЭБХХХХурлаар хэлэлцүүлэх материал гэх мэт/ /
- Шийдвэр гарна
- Хүсэлтийг хүлээн авсан мэргэжилтэн шийдвэрийн бүртгэлийг системд оруулан хүсэлт ирүүлсэн байгууллагыг сонгосноор тухайн байгууллагад хөрөнгө данснаас хасах тухай мэдэгдэл очно. Уг мэдэгдлийн дагуу хөрөнгө данснаас хассан авсан тэмдэглэл хөтөлнө /Үүнд: Даргын шийдвэрийн огноо, дугаар үнийн дүн гэх мэт/ /энэ хэсгийг ашиглан тогтоол шийдвэрийн биелэлт програмаас гарах боломжийг бүрдүүлэх/
- /Акталсан хөрөнгийн мэдэгдэл явуулахдаа дараах үйлдлүүдийг давхар хийдэг байх
 - Акталсан хөрөнгийг татан төвлөрүүлэх- татаж авах огноог оруулах,
 - Хоёрдогч түүхий эдээр худалдан борлуулах бол 30%-ийг төвлөрүүлэхээр тухайн байгууллага дээр авлага үүсгэх ,
 - Устгах- Устгалын актыг хавсаргах нэмэлт цонхыг идэвхжүүлж өгөх /

ШИНЭЭР ХИЙГДЭХ ПРОГРАМЫН МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛ

/Орон нутгийн өмчийн хувьд/



- Компанийн засаглал үйл ажиллагаа

Оролт

- Санхүүгийн тайлан /аудит/
- Зорилтын санал
- Зорилтот түвшин
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
- Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн тайлан
- Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл
- Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн мэдээлэл
- Төлөөлөн удирдах зөвлөлийн мэдээлэл
- Захирал, дэд захирал, ерөнхий нягтлан бодогчийн мэдээлэл
- Байгууллагын албан ёсны цахим хуудас
- Байгууллагын холбоо барих мэдээлэл
- Байгууллагын хаяг, байршлын мэдээлэл
- Байгууллагын бүтэц, орон тооны мэдээлэл
- Байгууллагын хүний нөөцийн нэгдсэн судалгаа
- Ногдол ашгийн мэдээлэл
- Төсвийн төлбөрийн мэдээлэл
- Үйл ажиллагааны чиглэл
- Үйл ажиллагааны тоон үзүүлэлтүүд
- Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл
- Өмч, хөрөнгийн мэдээлэл
- Байгууллагын нууцад хамааралгүй, ил тод нээлттэй мэдээллэх шаардлагатай баримт бичгүүд

Гаралт /салбараар, нэгдсэн байдлаар/

- Төрийн өмчтэй хуулийн этгээдийн нэгдсэн судалгаа
- Төрийн өмчтэй хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн нэгдсэн үзүүлэлт
- Төрийн өмчтэй хуулийн этгээдийн өмч, хөрөнгийн нэгдсэн үзүүлэлт

Гаралт /компани тус бүрээр/

- Компанийн нэгдсэн танилцуулга
- Компанийн засаглалын талаар танилцуулга
- Компанийн үйл ажиллагааны талаар танилцуулга
- Компанийн санхүү, эдийн засгийн нэгдсэн үзүүлэлт
- Компанийн санхүү, эдийн засгийн шинжилгээ
- Компанийн өмч, хөрөнгийн нэгдсэн үзүүлэлтүүд

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧ ХУВЬЧЛАЛ

Өмч хувьчлалын систем

Үл хөдлөх хөрөнгө

- Тухайн онд хувьчлах үл хөдлөх хөрөнгийн хувьчлалын жагсаалтыг байршуулна. /Үл хөдлөх хөрөнгө тус бүрийн хувийн хэргийн мэдээллийг байршуулна. Үүнд: Зураг, байршил, хүчин чадал ашиглалтад орсон огноо гэх мэт /Энэ мэдээлэл хэрэглэгчдийн түвшинд засварлах эрхгүйгээр харах болмжтой байна/
 - Хөрөнгийн зураг
 - Ашиглалтад орсон огноо

- Хүчин чадлын талаарх мэдээлэл
- Байршиг МАР ашиглан байршуулах
- Үнэлгээний компани сонгон шалгаруулахаас эхлээд өмч хувьчлах комиссын хурлаар хөрөнгийн анхны үнэ дэнчин үнэ өсөх шатлал тогтоох хүртэл үе шат бүрээр харагддаг байх
 - Үнэлгээ хийх компанийн сонгон шалгаруулалтын үнэлгээний хороо байгуулах
 - Үнэлгээ хийх компанийг сонгон шалгаруулах зар мэдээг нийтлэх
 - Шалгарсан компанийг нийтлэх
 - Шалгарсан компани үнэлгээг хийж дуусган, хүлээлгэн өгсөн тохиолдолд “Үнэлэгдсэн” гэсэн мэдэгдэл харуулах
 - Өмч хувьчлах комиссын шийдвэр гарсан гэх мэдээллийг мөн харуулна
 - Дуудлага худалдааны зар олон нийтийн мэдээллийн сувгаар цацагдсанаар дуудлага худалдаа хийгдэнэ.

Мөн тооллого хийх зэрэг хөрөнгөтэй холбоотой бүхий л мэдээллийн бүртгэнэ. Хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээлэл зураг, бичлэг, холбогдох бичиг баримтыг давхар хөтлөнө.

Хөрөнгө тоолох, дэлгэрэнгүй мэдээлэл оруулах хэсэг нь гар утасны аппликацийн төслийн байна.

Тухайн байгууллагын онцлогоос хамааруулан шулуун шугамын болон бусад аргаар тооцоололд тусгаж жил бүр тооцоолон нягтлан бодох бүртгэлийн мэдээлэлд оруулна.

3.2.4 Тайлан мэдээ

Өмчийн бүртгэлээс дараах тайлангуудын уян хатан гарган авах

- Статистикийн 15 маягт
- Төрийн өмчийн бүртгэлийн 12 маягт
- Өгөгдсөн үзүүлэлтээр харах болмжтой динамик тайлан
- Судалгааны маягт
- Мэдээ тайлангийн нэгтгэлүүд

3.2.5 Архивийн систем

Он дарааллаар архив үүсгэх, оноор өндөрлөх , архивлагдсан мэдээллийн засах шинэчлэх боломжгүй байх

3.2.6 Санхүүгийн систем

- Санхүүгийн e-balance системээс санхүүгийн 6 тайланг татаж авдаг байх .
- Санхүүгийн тайланд анализ, судалгаа хийгдэг байх
- Санхүүгийн тайлангийн нэгтгэл хийдэг байх

3.2.7 Түрээсийн систем

Төрийн өмчийн болон оролцоотой хуулийн этгээдүүдийн түрээслэж, түрээслүүлэж буй хөрөнгийн систем

- Түрээслүүлж байгаа хөрөнгийн систем
- Түрээсэлж байгаа хөрөнгийн систем
- Төрийн болон орон нутгийн өмчийн илүүдэлтэй байр талбайн мэдээлэл

- Сонгон шалгаруулалт зарлагдсан байр талбайн мэдээлэл
- Түрэсийн гэрээ
- Хүсэлт илгээх. /Хүсэлтийг илгээн өөрийн байгууллагад тохирсон гэрээний маягтыг авах/
- Төлбөрийн хуваарийн мэдээлэл /Зөвхөн гэрээ байгуулан ажиллаж буй хуулийн этгээд/

ТБОНӨ-т байгууллагын хувьд

- Төрийн болон орон нутгийн өмчийн илүүдэлтэй байр талбайн мэдээлэл
- Сонгон шалгаруулалт зарлагдсан байр талбайн мэдээлэл
- Гэрээ байгуулах
- Иргээс хүсэлт ирсэн тохиолдолд тухайн мэргэжилтэнд мэдэгдэл ирдэг байх. /Иргэний мэдээллийг шалган хаана хэдэн м.кв талбай, хэдэн төгрөгөөр түрээслэхээр болсныг нягтлан гэрээний төслийг боловсруулан бүртгүүлсэн цахим шуудангаар илгээх/
- Нэхэмжлэхийг бүртгэлтэй имэйл хаяг болон утасны дугаараар илгээх
- Төлбөрийн хуваарийн мэдээлэл /гэрээ байгуулсан бүх байгууллагад үүсгэнэ/ Гэрээ цуцлах /дарааллан 2-оос дээш сар төлбөр төлөөгүй бол бүртгэлтэй цахим шуудан болон утсаар мэдэгдэх хуудсыг илгээнэ./

Түрээсэлж, түрээслүүлж буй хуулийн этгээдийн мэдээлэл, хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох эрх бүхий этгээдүүдийн шийдвэр, үнэлгээ, түрэсийн үнэ, тайлан мэдээ, үнийн мэдээллийн анализ

3.2.8 Дуудлага худалдааны систем

Дуудлага худалдаа явуулах хүртэлх бүхий л процесийг бүртгэнэ.

- Байгууллагуудын өмч хамгаалах зөвлөлийн бүртгэл мэдээлэл
- Тухайн өмчтэй холбоотой гарсан шийдвэрүүдийн мэдээлэл
- Харьяа дээд байгууллагуудын шийдвэрүүдийн бүртгэл
- Худалдан борлуулалт, данснаас хасалт, орлогын бүртгэлийн мэдээлэл

Дуудлагаар худалдан борлуулах хөрөнгийн зар мэдээлэл, оролцогч бүртгэх, дуудлага худалдааны дэнчийгийн төлбөр авах, дуудлага худалдаа зохион байгуулах бүхий л үйл ажиллагааг хангасан веб, гар утасны системийн дэлгүүр байна.

3.2.9 Актлагдсан барааны дэлгүүр

Байгууллагуудын хэрэгцээ шаардалгаас илүү гарсан хөрөнгийг дуудлага худалдааны веб, гар утасны системтэй нэгтгэн боловсруулсан онлайн дэлгүүр байна.

- Байгууллагуудын өмч хамгаалах зөвлөлөөс гарсан шийдвэр, актлах бүтээгдэхүүний дэлгэрэнгүй мэдээлэл /зураг бичлэгтэй/
- Дээд байгууллагуудын шийдвэр
- Худалдан борлуулалт, данснаас хасах гм

3.2.10 Системийн дотоод хяналт

Системийн хэвийн найдвартай ажиллагаг хангах, гарсан алдааг засах, зарим үйлдэлийн автоматжуулах хэсэгтэй байна. Зарим шаардлагатай мэдээллийг холбогдох

төрийн байгууллагуудын мэдээллийн сантай тулган шалгаж мэдээлэх, давхардалыг шинэчлэх, мэдээлэх, хяналт тавих хэсэгтэй байна.

3.2.11 Хэрэглэгчийн тохиргоо

Хэрэглэгчийн хандах эрхийг нь тодорхойлон эрхийг хязгаарлана.

Тоон гарын үсэг, “ДАН” системийг ашиглан нэвтрэх эрхтэй байна.

3.2.12 Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын систем

Хуулийн этгээдийн дараах мэдээллийг агуулсан байна.

- Удирлагуудын мэдээлэл
- Санхүүгийн үзүүлэлт
- Хүний нөөцийн мэдээлэл
- Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээлэл
- Бусад

3.2.13 Албан бичиг хөтлөх систем

Албан байгууллага харьяа байгууллага бусад албан бичиг хөтлөлтийн системтүүдтэй уялдан ажиллах систем

- Албан бичиг ирсэн явсан бичиг
- Архив
- Тайлан мэдээ
- Цагийн бүртгэл
- Зар мэдээлэл
- Тоон гарын үсэг

3.2.14 Хөрөнгө оруулалтын систем

- Байгууллагатай холбоотой хөрөнгө оруулалтууд
- Их засвар үйлчилгээ
- Бусад

3.2.15 Өмч хувьчлал

- Хувьчлалтай холбоотой үйл ажиллагааны бүртгэл
- Хувьчлалын мэдээлэл байгууллагын веб хуудастай холбох

3.2.16 Хяналт шалгалтын мэдээлэл

- Хяналт шалгалтын төлөвлөгөө
- Гүйцэтгэл
- Холбоотой албан бичиг
- Үр дүн

3.2.17 Хууль, эрх зүйн систем

- Өмчтэй холбоотой хууль зүйн мэдээлэл
- Харилцагч байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцоо
- Хууль журамын талаар санал авах
- Маргаан шийдвэрлэлтийн мэдээлэл

3.2.18 Системийн байгууллагуудын чат, мэдээллийн веб хуудас

- Харьяа байгууллагуудын хоорондын чат систем
- Орон нутаг өмчийн байгууллагуудын веб сайт

3.2.19 Нэмэлтээр хийгдэх ажил

- Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний систем
- Тоон гарын үсгийн системд холбох

- Няравын програм
- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн систем
- Байр зүйн системтэй холбогдох
- Бусад боломжууд

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

| БОЛОМЖУУД

ТӨРИЙН
ӨМЧИЙН
БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗАР



Хөрөнгийн карт
хэвлэх
/QR код доджуулах/



QR код унших



Няравын
программын
модуль



Өмч хамгаалах
байнгийн зөвлөлийн
модуль



Хүчирхэг хайлтын
систем



Үстгасан мэдээлэл
сэргээх боломж



Хөрөнгийн элэгдэл
олон янзаар
автоматаар бодох



Цахим гарын үсэг
бүхий лавлагаа
олгох боломж



Өмчийн бүртгэлийн
стандартыг мөрдлөг
болгох



Өмчийн бүртгэлийн
стандартыг мөрдлөг
болгох
байдаг
чанар ангилалаас
хамааруулан
динамикаар өөрчилж
бодог байх


ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

ТӨРИЙН
ӨМЧИЙН
БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗАР



УХААЛАГ ГАР УТАСНЫ СИСТЕМТЭЙ ХОЛБОГДСОН БАЙХ

- Дуудлага худалдаа
- Түрээс
- Актлагдсан барааны дэлгүүр
- Лавлагага /Хөрөнгийн лавлагага/
- Данснаас хасагдах хөрөнгийн систем



5 ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- Програм хангамж нь Enterprise мэдээллийн систем хөгжүүлэх JAVA эсвэл PHP технологи дээр боловсруулагдана.
- Програм хангамжийн өгөгдлийн сан нь Mysql, PostgreSQL эсвэл NoSql төрлийн MongoDB, Cassandra буюу түүнтэй дүйцэхүйц төрлийн нээлттэй эх дээр суурилсан өгөгдлийн сан байна.
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Application Development Framework ашигласан байна.
- Вебэд суурилсан байна. Түгээмэл хэрэглэгддэг бүх төрлийн веб хөтөч дээр ажилдаг байна.
- Програм хангамжийн зохиогчийн эрхийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эзэмших бөгөөд гүйцэтгэгч тал дахин ашиглах, ижил төрлийн үйл ажиллагаанд дахин ашиглахгүй байна.
- Програмын эх код, өгөгдлийн урсгалын диаграм, классийн диаграм, UML, кодын тайлбар, програм өөрчлөлт оруулах нэмж хөгжүүлэхэд шаардлагатай гарын авлага зааваруудыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүлээлгэн өгнө.
- Програм хангамж нь Монгол болон Англи хэл дээр байна. Цаашид хэл нэмэх боломжтой орчуулгийн модуль бүхий байна.
- Програм хангамж хөгжүүлсэн технологи нь лицензтэй тохиолдолд холбогдох лицензийн төлбөрийг гүйцэтгэгч тал хариуцна.
- 2022 оны 12 сарын 10-ны дотор програм хангамжийн бүрэн тест тохируулга хийгдэж, ажилд оруулсан байна.
- 2023, 2024, 2025 онуудад үнэ төлбөргүй програм хангамжийн шинэчлэлийг захиалагчийн хүсэлтээр хийнэ.

5.1 ТЕХНИК ХАНГАМЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл хяналтын системд ашиглах хэрэглэгчийн компьютерийн үзүүлэлт нь хамгийн баагдаа доорхи үзүүлэлттэй байна.

- Процессор: Dual Core буюу түүнээс дээш байхад ажиллах боломжтой байх
- Санах ой: Эцсийн хэрэглэгчийн компьютерийн санах ой 2GB буюу түүнээс дээш байхад ажиллах боломжтой байх
- Хатуу диск: 80GB буюу түүнээс дээш байхад ажиллах боломжтой байх
- Гар утасны android IOS систем дээр хийгдсэн апликацийтай байна.

5.2 СҮЛЖЭЭ БА ХОЛБОЛТЫН ТОДОРХОЙЛОЛТ

- Web server, file server, email server, data server зэрэг төрлүүдтэй, хэрэглэгчдэд мэдээлэл оуулах авахад хялбар хурдтай байхаар зорхицуулагдсан байна.
- Монгол улсын интернетийн холболт удаан алслагдсан сум суурингаас холбогдон ажиллах мэдээлэл дамжуулах, авах хялбаршуулсан хувилбартай байна.
- Вэб сервер болон өгөгдлийн сангийн сервер сүлжээний орчинд ажиллах боломжтой байх

5.3 ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ЕРӨНХИЙ ТОДОРХОЙЛОЛТ

- Хүнд ойлгомжтой, энгийн, дизайны орчин үеийн чиг хандлагад нийцсэн байх
- Хэрэглэгчийн эрхийн олон түвшинтэй уян хатан ангилалтай байх
- Хэрэглэгчийн түвшинд ижил дизайнтай байх
- Сүлжээний бага хурдад ажиллах хөнгөн байх
- Динамик бүтэцтэй байх
- Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой бүх процессыг тус програм хангамжаар дамжуулан хийгддэг болгох /цахимжуулах/
- Үл хөдлөх хөрөнгө, газар гэх мэт хөрөнгүүдийн бүртгэлийг орон зайн мэдээллийн сантай холбох
- Өмчийн мэдээлэлд хиймэл оюун ухаанаар аналитик тайлан хийж мэдээлдэг байх.
- Програм хангамжаас гарах бүх төрлийн тайланг MS Excel, MS Word, PDF форматаар гаргах боломжтой байх
- Санхүүгийн програм, Төрийн бусад байгууллага, ХУР системээс мэдээлэл авах, мэдээлэл дамжуулах боломжтой байх
- Он оноор мэдээллийн архив үүсгэдэг байх, архиваас мэдээлэл хараад хялбар байх
- Олон хэлний сонголттой байх

Шинээр хийгдэхээр төлөвлөж буй систем нь төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын мэдээлэл, тэдгээр хуулийн этгээдүүдийн засаглал үйл ажиллагааны үр дүн тайлagnal, төрийн нийтийн ба тусгайлсан өмч. орон нутгийн өмч хөрөнгийн төлөв байдал тэдгээрийн хөдөлгөөн /олж авах, шилжүүлэх, данснаас хасах/, Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад ашиглуулах гэрээний бүртгэл /эд хөрөнгө, эрхийн улсын бүртгэлтэй холбох/, хяналт шалгалт, үнэлгээний тайлан зэрэг цогц мэдээллийг агуулсан бүтэцтэй байхаар төлөвлөсөн болно.

5.4 СИСТЕМИЙН УДИРДЛАГА, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийгдсэн байх
- Кибер аюулгүй байдлын нөхцөл шаардлагыг бүрэн хангасан байх
- Эцсийн хэрэглэгчдэд ойлгомжтой энгийн алдааны мэдэгдэлтэй байх. Гарч болох энгийн алдаа бүрийг тооцон барьсан байх

5.5 БАРИМТЖУУЛАЛТЫН ШААРДЛАГА

- Системийн анализ ба дизайн хүлээлгэн өгөх
 - 1.7.1.1 Системийн архитектур
 - 1.7.1.2 Ерөнхий зураглал
 - 1.7.1.3 Нарийвчилсан зураглал
- “Use Case” диаграм хүлээлгэн өгөх
- “Mockup” зураглал батлуулах
- “Activity” диаграм хүлээлгэн өгөх
- “Sequence” диаграм хүлээлгэн өгөх
- Өгөгдлийн сангийн бүтцийн диаграм баримтжуулан хүлээлгэн өгөх
- Хүснэгт, хүснэгтийн талбарын тайлбарыг баримтжуулан хүлээлгэн өгөх
- Хэрэглэгчийн шаардлагын өөрчлөлт баримтжуулан хүлээлгэн өгөх
- Програмын эх кодын тайлбарыг хүлээлгэн өгөх

- Тестийн үр дүнг баримтжуулан хүлээлгэн өгөх
- Програмын гарын авлага хүлээлгэн өгөх
- Систем суурилуулалтын гарын авлага хүлээлгэн өгөх
- Асуудал шийдвэрлэх /troubleshooting/ гарын авлага хүлээлгэн өгөх
- Програм хангамж хүлээлцсэн акт хүлээлгэн өгөх
- Системийг суурилуулан хэвийн ажиллах хамгийн бага техник хангамжийн үзүүлэлтийг баримтжуулан хүлээлгэн өгөх
- Програмын “Prototype” –ийг баталгаажуулан хүлээлгэн өгөх
- Төслийн багийн гишүүдийн ажил үүргийн хуваарь баталгаажуулан хүлээлгэн өгөх
- “Entity Relationship” диаграм баталгаажуулан хүлээлгэн өгөх
- “User Interface” програмын дизайн баталгаажуулан хүлээлгэн өгөх

5.6 СУРГАЛТ

- 1.8.1 Функциональ түвшний хэрэглэгчийн сургалт зохион байгуулах
- 1.8.2 Програм хангамжийг ашиглах цахим гарын авлага видео хичээл бэлдэх
- 1.8.3 Системийн инженерүүдэд сургалт зохион байгуулах
- 1.8.4 Програм хангамжийн инженерүүдэд програмын эх кодын сургалт зохион байгуулах
- 1.8.5 Системийн удирдаагчдад системийн удирдлагын, тайлангийн загварчлалын сургалт зохион байгуулах
- 1.8.6 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2-н мэргэжилтэнийг тухайн програмыг хөгжүүлсэн програмын хэл, application framework-ийн сургалтанд сургалтанд хамруулсан байх
- Байгууллага орон нутагт сургалт зохион байгуулах

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЛБА